



**НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“5. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 16квт/цагаас дээш хүчин чадалтай халаалтын зуухыг цахилгаан, дулаан хангамжаар халаах ажлын явцын тухай танилцуулгыг Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөр танилцуулав.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос хийж хэрэгжүүлж буй ажлын талаар Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны нарийн бичгийн дарга Ч.Гантулга, “Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэж буй сайжруулсан түлшний үйлдвэрлэлт, тээвэрлэлт, түгээх үйл ажиллагааны явцыг “Тавантолгой түлш” ХХК-ийн Борлуулалтын хэлтсийн дарга Д.Миняа нар тус тус танилцуулав.

Энэ асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн үүрэг даалгавар:

1. Сайжруулсан түлшний борлуулалтын цэгүүд хүртэлх тээвэрлэлтийн үйл ажиллагаанд нь хяналт тавьж, нийлүүлэгч, санхүүжүүлэгч, тээвэрлэгч болон холбогдох аж ахуй нэгж, байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангаж ажиллахыг Агаар, орчны бохирдол хариуцсан төслүүдийн удирдагч /Д.Мөнхжаргал/;

2. Сайжруулсан түлшний борлуулалтын цэгүүд хүртэлх тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулалтын оновчтой шийдлээр шинэчлэн ажиллуулахыг Агаар, орчны бохирдол хариуцсан төслүүдийн удирдагч /Д.Мөнхжаргал/, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/-нд;

3. Сайжруулсан түлшний тээвэрлэлтийн гүйцэтгэгчээр шалгарсан компаниудтай уулзалт хийж, 2019 оны 09 дүгээр сарын 06-ны өдөрт багтаан гэрээ байгуулах, өдөрт 10-15 мянган тонн сайжруулсан түлш тээвэрлэн борлуулалтын цэгүүдэд 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор хүргэх ажлыг зохион байгуулахыг Агаар, орчны бохирдол хариуцсан төслүүдийн удирдагч /Д.Мөнхжаргал/-д, “Тавантолгой түлш” ХХК /М.Ганбаатар/-нд;

4. Дүүргийн Засаг дарга, гэр хорооллын хороодын Засаг дарга нарыг “Тавантолгой түлш” ХХК-ийн үйл ажиллагаатай танилцуулах уулзалт зохион байгуулахыг Агаар, орчны бохирдол хариуцсан төслүүдийн удирдагч /Д.Мөнхжаргал/-д;

5. Хэсгийн ахлагч нарыг барьцаагүйгээр сайжруулсан түлшний борлуулагчаар хороондоо ажиллуулах гэрээ байгуулж ажиллахыг Агаар, орчны бохирдол хариуцсан төслүүдийн удирдагч /Д.Мөнхжаргал/-д дүүргийн Засаг дарга нарт;

6. Борлуулагчаар ажиллах иргэдийн 2 сая төгрөгийн барьцаа төвлөрүүлэх банкны асуудлыг шийдвэрлэх, банк сонгох асуудлыг нээлттэй болгож ажиллахыг "Тавантолгой түлш" ХХК /М.Ганбаатар/-нд;

7. Цайз зах болон бусад газруудаар сайжруулсан түлшний уутанд түүхий нүүрс болон орон нутагт үйлдвэрлэсэн чанарын шаардлага хангахгүй түлш хийж зарж байгаа учир газар дээр нь очиж шалган, бодитой үнэлэлт, дүгнэлт өгч, таслан зогсоохыг Нийслэлийн Цагдаагийн газар /Д.Ядамдорж/-т, иргэдийг үнэн зөв мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс /Ц.Мөнхбаатар/-т;

8. Амралтын өдрүүдэд сайжруулсан түлшийг бүх дүүрэг хороо, борлуулалтын цэгүүдэд хүргэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Агаар, орчны бохирдол хариуцсан төслүүдийн удирдагч /Д.Мөнхжаргал/-д, "Тавантолгой түлш" ХХК /М.Ганбаатар/-нд, хяналт тавьж, заавар зөвлөгөө өгч ажиллахыг Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо /Ч.Гантулга/-нд;

9. "Тавантолгой түлш" ХХК-ийн үйлдвэрээс сайжруулсан түлшийг нийслэлийн дүүрэг, хороо, борлуулалтын цэгүүдэд тээвэрлэх, түгээх үйл ажиллагаанд 9 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл 24 цагийн хугацаанд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган шаардлагатай арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг нийслэлийн Засаг даргын орлогч, төслүүдийн удирдагч нар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга, Тамгын газар, Захирагчийн ажлын албаны хэлтсийн дарга нар, төвийн 6 дүүргийн Засаг дарга нарт;

10. "Тавантолгой түлш" ХХК-ийн үйлдвэр, дундын хадгалах агуулах борлуулалтын цэгүүдийн замын орц, гарц, сайжруулсан түлш ачих, буулгах нөхцөл боломжийг бүрдүүлэх, шөнийн цагт гэрэлтүүлэг тавих, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангуулах, түлш тээвэрлэж буй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд саадгүй оролцох боломжоор хангах, арга хэмжээг авч ажиллахыг "Тавантолгой түлш" ХХК /М.Ганбаатар/-т, тээвэрлэгч компани, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газар /Д.Дашдорж/-т, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/-т, Нийслэлийн Цагдаагийн газар /Д.Ядамдорж/-т тус тус;

11. Хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, удирдлагаас өгсөн үүрэг даалгавар биелүүлээгүй хангалтгүй ажилласан албан тушаалтнуудад хариуцлага тооцохыг Агаар, орчны бохирдол хариуцсан төслүүдийн удирдагч /Д.Мөнхжаргал/-д дүүргийн Засаг дарга нарт;

12. "Тавантолгой түлш" ХХК-ийн үйлдвэр дээр сайжруулсан түлшийг нийслэлийн дүүрэг, хороо, борлуулалтын цэгүүдэд тээвэрлэх, түгээх үйл ажиллагаанд 24 цагийн байнгын хяналт тавьж, ажлын явц, тулгамдаж байгаа асуудлын талаар цаг тутамд нийслэлийн удирдлагуудад танилцуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс /Х.Гантулга/-т, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч /Ж.Батбаясгалан/-д тус тус үүрэг болгов" гэжээ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

